МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 31 № 24/ТУЗ/26 Улаанбаатар хот

⌈ Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай ⌉

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.14.27, Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2024 оны 5 сарын 31-ний өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Төв Азийн Зам” ХХК /РД:5618819/-ийн нийт энгийн хувьцааны 51%-ийг энэхүү тогтоолын Хавсралтад заасан үнэ, нөхцөлөөр худалдан авахыг “Монложистикс Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д зөвшөөрсүгэй.
2. Монложистикс Холдинг ХК-ийг төлөөлөн хувьцаа худалдан авах, эзэмших асуудлаар холбогдох гэрээ байгуулах, гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, үр дүнг ТУЗ-д тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д үүрэг болгосугай.
   Энэхүү тогтоолыг холбогдох баримт бичгийн хамт ажлын 1 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Ц.Дуламсүрэн/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.ГАНЗОРИГТ

МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК
monlogistics HOLDING
АТА11138 ☏ 6381251
9023121052

МОН ЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК
logistics
HOLDING
АТА1113В 6381251
9023121052

# МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ №24/04-1

| | | |
|---|---|---|
| **Огноо, цаг** | 2024 оны 5-р сарын 31-ний өдөр (Баасан гараг) 10:00-13:00 | |
| **Хурал хийсэн байршил** | Хурлын өрөө, 1101 тоот, Нью Хоризонс оффис, Олимпын гудамж, Улаанбаатар хот | |
| **Цаг, үргэлжилсэн хугацаа** | 10:00-13:00 хүртэл нийт 3 цаг | |
| **Хэлбэр** | Биечлэн болон цахимаар оролцсон хурал | |
| **Хурлын дарга** | **ТУЗ-ийн дарга:** Л. Ганзоригт | биечлэн |
| **Хурлын ирц:** | **ТУЗ-ийн гишүүд:** Э. Оюунбилэг, Б. Тэлэнгэд, Ө. Ганзориг, Б. Энхтүвшин, С. Сайнбат | биечлэн |
| | **ТУЗ-ийн гишүүн:** С. Энх-Амгалан, | цахим |
| | **ТУЗ-ийн гишүүн:** Г. Цэрэнпүрэв | саналын хуудсаар |
| | **MLH ХК-ийн Гүйцэтгэх захирал** Г. Хишигбат | биечлэн |
| **Ажиглагчаар:** | | |
| **ТУЗ-ийн НбДарга** | Ц. Дуламсүрэн | биечлэн |
| **Хурлын ирц** | Хуралд оролцвол зохих 9, хуралд оролцсон 9 . | Хурлын ирц 100% |

## ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

1. Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай

Танилцуулсан: Гүйцэтгэх захирал Г. Хишигбат

Монложистикс Холдинг ХК нь Төв Азийн Зам ХХК-ийн энгийн хувьцааны 51%-ийг худалдан авах due diligence хийж, дүгнэлт гаргасанаа ТУЗ-ийн хуралд танилцуулав.

Гэрээ байгуулагдсаны дараа Монложистикс Холдинг ХК-ийн зүгээс менежментийн зөвлөх үйлчилгээний хүрээнд яаралтай болон төлөвлөгөөт байдлаар хийгдэх ажлуудыг танилцуулж, гэрээ байгуулахыг зөвшөөрөх эсэх санал хураав.

## ХУРЛААС ГАРСАН ШИЙДВЭР

1. “Төв Азийн Зам” ХХК-ийн нийт энгийн хувьцааны 51%-ийг ТУЗ-д танилцуулсан (тогтоолд хавсралтаар оруулах) үнэ, нөхцөлөөр худалдан авахыг “Монложистикс Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д зөвшөөрөх;
2. Монложистикс Холдинг ХК-ийг төлөөлөн хувьцаа худалдан авах, эзэмших асуудлаар холбогдох гэрээ байгуулах, гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д олгох;
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, үр дүнг ТУЗ-д тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д үүрэг болгох;
4. Энэхүү тогтоолыг холбогдох баримт бичгийн хамт ажлын 1 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Ц.Дуламсүрэн/-д даалгах;

(гарын үсэг дараагийн хуудсанд)

| | | | |
|---|---|---|---|
| Тэмдэглэлтэй танилцаж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлыг баталсан: | | Л. Ганзоригт | ТУЗ-ийн дарга |
| | | Б. Тэлэнгэд | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| | | Э. Оюунбилэг | ТУЗ-ийн хараат бус гишүүн, АЭУХорооны дарга |
| | | Г. Цэрэнпүрэв | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| | | С. Энх-Амгалан | ТУЗ-ийн хараат бус гишүүн, НДбЦУХорооны дарга |
| | | Ө. Ганзориг | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| | | Б. Энхтүвшин | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| | | Г. Хишигбат | ТУЗ-ийн ердийн гишүүн |
| Хурлын тэмдэглэл хөтөлсөн: | | Ц. Дуламсүрэн | ТУЗ-ийн НбД |

## “МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ САНАЛЫН ХУУДАС

Саналын хуудас хүлээн авах сүүлчийн хугацаа: 2024.05.30

Гишүүний овог, нэр: Тогоо Цэрэнпүрэв

Ердийн болон хараат бус гишүүний аль нь болох: хараат бус гишүүн

И-мэйл хаяг: g.tserenpurev80@gmail.com

Холбогдох утас: 99119045

| № | Хэлэлцэх асуудал | ТУЗ-ийн гишүүний саналын хувилбар | | |
|---|---|---|---|---|
| | | Зөвшөөрсөн /+/ | Татгалзсан /+/ | Түтгэлзсэн /+/ |
| 1 | Төв азийн зам ХХК-ийн 51%-ийг худалдан авах гэрээ байгуулах зөвшөөрөл олгох | + | | |
| 2 | MSM ХХК-иас бартерийн нөхцөлөөр автомашин худалдан авах зөвшөөрөл олгох | + | | |
| 3 | Иргэн Гэрэлмаагаас чиргүүлтэй автомашин худалдан авах зөвшөөрөл олгох | + | | |
| 4 | ХХБ-тай зээлийн шугамын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай | + | | |

Санал өгсөн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн: .......................................... Г. Цэрэнпүрэв.

(Гарын үсэг)

2024.05.30